

**Петро Матад Лимитед
/цаашид “Петро Матад” юмуу эсвэл “Компани” гэх/
Захирлуудын Зөвлөлд Орж Буй Өөрчлөлтүүд**

Петро Матадын ТУЗ нь хадагтай Мари Эллен Коллинс болон хадагтай Даваанямын Энхчимэг нарыг тус Компаний Захирлуудын Зөвлөлийн гишүүдээр томилж нэн даруй уг албан тушаалд ажиллуулах болсноо мэдэгдэхэд таатай байна.

Хадагтай Коллинс нь 2009 оны 12 сарын 18-нд зарласан Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкнаас /ЕСБХБ/ тус Компанид оруулсан 6 сая ам.долларын хөрөнгө оруулалттай холбоотойгоор ийнхүү томилогдож байгаа болно.

Хадагтай Коллинс /65 настай/ нь олон улсын арилжааны банкны системд 30 гаруй жил ажилласан Үүн Европ болон Төв Азийн талаар арвин туршлагатай хүн. Тэрээр хожим нь Банк оф Америкад худалдагдсан Секюрити Пасифик Нэйшнл Банк, түүнээс өмнө Чейс Манхатен Банк зэрэг банкуудад бизнес харилцагчдийн менежмент болон эрсдлийн менежментийн чиглэлээр өндөр албан тушаал хашиж байжээ. 1998 оноос ЕСБХБ-ны Эрсдлийн Менежментийн хэлтэст ажиллаж 2003-аас 2005 он үртэл Бизнесийн Эрүүлжүүлэлт х ариуцсан захирлаар ажилласан байна. Хадагтай Коллинс Пенсильваниагийн Их Сургуулийн Уартон Сургуулиас Бизнесийн Удирдлагын Мастер зэрэг хүртсэн ажээ.

Хадагтай Энхчимэг /36 настай/ нь Петровис ХХК-ий Гүйцэтгэх Захирал. 2008 онд Петровис ХХК-нд ажиллаж эхлэхээсээ өмнө Монгол улсын Худалдаа Хөгжлийн Яаманд ажиллаж байсан бөгөөд Эрдэнэс Монгол ХК -ий Хөрөнгө Оруулалт, Төлөвлөлтийн Хэлтсийн даргаар ажиллаж байжээ. Эрдэнэс Монгол ХК нь төрийн өмчлөлийн бизнесийн байгууллага бөгөөд ашигт малтмалын байгууллагууд дахь Монгол улсын хувьцаануудыг эзэмшин захирах зорилгоор байгуулагдсан компани юм. Хадагтай Энхчимэг нь АНУ-ын Сити Групп Даатгалын Хөрөнгө Оруулалтын компанид хөрөнгө оруулалтын шинжээчээр мөн ажиллаж байсан бөгөөд Колорадогийн Их Сургуулийн Бизнесийн Удирдлагын Мастер зэрэг хүртжээ.

Энэхүү томилгооны талаар Петро Матадын Гүйцэтгэх Захирал Даг МакГей хэлэхдээ:

“Хадагтай Мари Элен манай ТУЗ-д нэгдэн орохыг өвшөөрсөнд бид маш их баяртай байна. Түүний санхүүгийн арвин их туршлага, хөгжиж буй зах зээлүүдэд үйл ажиллагаа явуулдаг компаниудад ажилласан батлагдсан амжилтууд нь манай Компанийг бэхжүүлэн хөгжлийн шинэ шатанд гаргахад үнэтэй хувь нэмэр болох болно. Түүний ЕСБХБ -нд ажилласан туршлага нь манай Компаний хувьцаа эзэмшигч болох тус Банктай харилцах Петро Матадын харилцааг улам бүр бэхжүүлэх болно.

“Бид мөн хадагтай Энхчимэгийг тайнай ТУЗ-д тавтай морилохыг урьж байгаадаа таатай байна. Үүний Монгол улсад болон олон улсын худалдаа арилжааны

мэдлэг чадвар манай Компанид асар үрх өгөөжөө өгөх болно. Тэрэ эр мөн Монголын олон бие даасан өрөнгө оруулагчдын дунд зуучлах гүүр болохоосж гадна Петровис компанитайнэ цэнэтэй хамтын ажиллагааг улам цааш өргөжүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулах болно”.

Хадагтай Коллинс 1998 оноос Геопотс ХХК-ийн захирлаар 2010 оны 4 сар хүртэл ажилласан. Хадагтай Энхчимэг Петровис ХХК-ий захирлаар 2008 оны 1 сараас эхлэн ажиллаж байна.

Хадагтай Коллинс болон хадагтай Энхчимэг нар дээр дурьдсан захирлуудын ажил эрхэлж байснаасөөрөөр Компаниудын Алтернатив Хөрөнгө Оруулалтын н Зах Зээлийн Журмуудын Хавсралт 2-ын параграф /ё/-д заасанчлан зайлшгүй мэдэгдэх шаардлагатай бусад зүйлс байхгүй болохыг баталцгаасан болно.

Редакторуудад зориулсан санамж:

Петро Матадын тухай

Петро Матад нь газрын тосны хайгуул болон цаашдын олборлолт, үйлдвэрлэлийг Монгол улсад эрхлэх чиглэлээр ажиллаж байгаа группын толгой компани юм. Тус групп нь Монгол улсын засгийн газартай байгуулсан гурван Бүтээгдхүүн Хуваах Гэрээнүүдийг дангаараа гүйцэтгэгч байгууллага болно. Гол хөрөнгө нь тус орны алс дорнодод байрлах 14,250 квадрат км талбай бүхий газрын тосны ХХ блокд байгуулсан Бүтээгдхүүн Хуваах Гэрээт талбай. Нөгөө хоёр 4 ба 5-р блокууд нь Монгол улсын төв хэсэгт байрлах бөгөөд хамтдаа 73,498 квадрат км талбайтай.

Петро Матал Лимитед компани нь Айсл оф Мэн аралд 1483В гэсэн бүтгэлтэй байгуулагдсан компани өгөөд албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Байшин, Проспет Хилл, Дуглас, Айсл оф Мэн, Ай Эм 1 –ИКю хаягт байрладаг болно.

Цаашдын мэдээллийг дараах хаягаар авч болно:

Петро Матад Лимитед
Дуглас Жэй. МакГэй- Гүйцэтгэх Захирал +976-11-331099

Вестхаус Секюритис Лимитед
Ричард Бэйти / Петре Нортон +44/0/ 20 7601 6100

Банкны талын зөвлөхүүд
Саймон Розсчайлд / Оливер Винтерс / Луйс Мэйсон +44/0/ 20 7367 8888